

ГАДААД ХЭРЭГ, ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРЭГ,  
САНХҮҮ, ЭДИЙН ЗАСАГ, БАТЛАН ХАМГААЛА-  
ХЫН САЙД, ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ





2001 оны 7 дугаар  
сарын 06-ны өдөр

Дугаар *65/249/226/325/210* Улаанбаатар  
хот

Судалгаа, мэдээ, мэдээлэл  
явуулж байх тухай

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан  
“Төрийн байгууллагуудын хооронд солилцох мэдээлэл”-ийг сайжруулах  
ажлын шаардлагыг харгалзан ТУШААХ НЬ:

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын гадаад таатай орчин  
бүрдүүлэх бодлогын хүрээнд хөрш орнуудын улсын хилийн харилцааг  
зохицуулахад шаардлагатай энэхүү тушаалын хавсралтад заасан зарим  
судалгаа, мэдээ, мэдээллийг Гадаад хэргийн яаманд нууцлалтын журамд  
нийцүүлэн, зохих журмын дагуу, тогтоосон хугацаанд тогтмол ирүүлж байхыг  
Зэвсэгт хүчний ерөнхий штабын дарга, дэслэгч генерал Ц.Дашзэвэг, Хилийн  
цэргийг удирдах газрын дарга, хошууч генерал П.Сүндэв, Гаалийн ерөнхий  
газрын дарга Х.Баатар, Цагдаагийн ерөнхий газрын дарга, хошууч генерал  
Ч.Амарболд, Тагнуулын ерөнхий газрын Төрийн захиргаа, төлөвлөлт,  
шинжилгээ, үнэлгээ, хяналтын газрын дарга Л.Батбаатар нарт даалгасугай.

<p>ГАДААД ХЭРГИЙН САЙД</p>  <p>Л.ЭРДЭНЭЧУЛУУН</p>	<p>ХУУЛЬ, ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД</p>  <p>Ц.НЯМДОРЖ</p>
<p>САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД</p>  <p>Ч.УЛААН</p>	<p>БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД</p>  <p>Ж.ГҮРРАГЧАА</p>
<p>ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА</p>  <p>М.БАТСАЙХАН</p>	

204.



Гадаад хэрэг, Хууль зүй, дотоод хэрэг,  
Санхүү, эдийн засаг, Батлан хамгаала-  
хын сайд, Тагнуулын ерөнхий газрын  
даргын 2001 оны тоот хамтарсан  
тушаалын хавсралт

65/249/226/325/210

ГАДААД ХЭРГИЙН ЯАМАНД ТОГТМОЛ ИРҮҮЛЖ  
БАЙХ СУДАЛГАА, МЭДЭЭ, МЭДЭЭЛЛИЙН  
ЖАГСААЛТ

1.Зэвсэгт хүчний ерөнхий штаб

- 1.Монгол улсын геополитикийн орчны байдлын тухай мэдээлэл / 7 хоногийн мэдээгээр хүргүүлж байх/.
- 2.Цэргийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны тухай мэдээлэл /7 хоногийн мэдээгээр хүргүүлж байх/.
- 3.Хөрш орнуудын хил орчмын нутгийн дотоодын байдлын тухай мэдээлэл / 7 хоногийн мэдээгээр хүргүүлж байх/

2.Хилийн цэргийг удирдах газар

- 1.Улсын хилийн болон хилийн боомтын цагийн байдлын тухай үнэлгээ, дүгнэлт /улиралд, дараа сарын 10-ны дотор/.
- 2.Хилийн боомтоор нэвтэрсэн, нэвтэрхийг завдсан зорчигч, тээврийн хэрэгслийн мэдээ /улиралд, дараа сарын 10-ны дотор/.
- 3.Боомт болон боомт бус газраар улсын хилийг нэвтэрсэн букуу нэвтрэхийг завдсан зөрчлийн судалгаа /улиралд, дараа сарын 10-ны дотор/.
- 4.Хилээр нэвтрүүлэн өнгөрүүлэх баримт бичиг, тэдгээрийг батламжлах тэмдгийн шинэ загвар, зорчигч, тээврийн хэрэгсэлд хийх шалгалтын горимд орсон өөрчлөлтийн тухай мэдээлэл /өөрчлөлт орсон тухай бүрт/.
- 5.Хөрш орнуудын болон улсын хил орчмын нутаг дэвсгэрт гарсан байгаль орчин, оршин суугчид, амьтдын эрүүл мэнд, аюулгүй байдалд занал учруулахуйц байгалийн гамшиг, гоц халдварт өвчний тухай мэдээлэл /тухай бүрт нь/.

- 6.Хилийн цэргийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны тухай мэдээлэл /хагас, бүтэн жилээр/.

3.Цагдаагийн ерөнхий газар



Улсын хил, хил залгаа аймаг, сумын нутагт гарсан эрүүгийн гэмт хэргийн мэдээ /сар бүр/.

#### 4.Гаалийн ерөнхий газар

1.Хилийн боомтоор нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгсэл, барааны гаалийн судалгаа, мэдээ, мэдээлэл /сар бүр/.

2.Гаалийн зөрчлийн судалгаа, мэдээ, мэдээлэл /сар бүр/.

3.Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон зүйлийг тээврийн хэрэгсэл, ачаа бараанд нууж улсын хилээр нэвтрүүлэхээр хэрэглэсэн арга, хэлбэрийн тухай мэдээ /сар бүр/.

4.Улсын хилийн боомтууд дээр хурааж буй гаалийн татвар, хураамж, ногдуулж байгаа торгуулийн нэгдсэн судалгаа /сар бүр/.

#### 5.Тагнуулын ерөнхий газар

1.Улсын хилийн аюулгүй байдал болон хил орчмын цагийн байдлын тухай мэдээлэл /сар бүр/.

2.Улсын хилээр хууль бусаар зэвсэг, хар тамхи, мансууруулах, хордуулах бодис болон контрбандын зүйлийг нэвтрүүлэх сувгийг илрүүлсэн тухай мэдээлэл /улирлаар/.

3.Хорлон сүйтгэх, алан хядах хэрэгсэл болон хар тамхийг улсын хилээр нэвтрүүлэх арга хэлбэрийн тухай мэдээлэл /улирлаар/.

4.Хилийн аюулгүй байдалд холбогдол бүхий мэдээ, мэдээлэл /сар бүр/.

5.Улсын хилийн бодлогод нөлөөлөх улс төрийн хүрээнд хийх зарим үнэлгээний тухай мэдээ /тухай бүрт нь/.

6.Хилийн бодлогод нөлөөлөх хуулийн хүрээнд хийх зарим үнэлгээний тухай мэдээ/тухай бүрт нь/.

7.Улсын хилийг хууль бусаар нэвтрэгсэд, монгол улсын гадаад паспорт засварлаж, хил гарахыг завдсан хүмүүсийн судалгаа, мэдээ, мэдээлэл /сар бүр/.